





*Хувьцаа эзэмшигчдийн
хурал, түүнийг оновчтой
зохион байгуулах нь*

*ХШГ, ҮЦХХ-ийн хянан шалгагч
А.Нинжсин*





Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: /Компанийн тухай хуулийн 62.1/

- компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
- нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
- компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- компанийн хэлбэрийг өөрчлөх;
- компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
- хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох гэх мэт.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна. /Компанийн тухай хуулийн 60.3/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

- Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчид хүргэх үүрэгтэй. /Компанийн тухай хууль 60.4/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ ГАРГАХ БҮРТГЭЛИЙН ӨДӨР

- Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй ба хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 10 дахь өдөр байхаар тогтооно. /"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.5/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хурал зарлагч этгээд нь хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор Хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлнэ./"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.6/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ҮЙЛЧИЛЖ БУЙ БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИД

- Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зар мэдээг нийтэд анх хүргэсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хүргүүлнэ./"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 3.10/

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ

- Ээлжит хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт 6 дугаар сарын 01-ний дотор, ээлжит бус хурлын материалыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор Хороонд ирүүлэх /"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.10/



Хурал хуралдуулах тухай шийдвэр

/Компанийн тухай хуулийн 60.2/

- хурал хуралдуулах газар, өдөр, цаг;
- хурлын хэлэлцэх асуудал;
- хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;
- хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт;
- саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны агуулга;
- саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;
- хурлын дарга;
- тооллогын комиссын дарга, гишүүд

Хурлын мэдэгдэл /"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.7/

- хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр;
- хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар;
- саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66.1-т заасны дагуу хурлын хэлэлцэх асуудалд санал оруулсан бол түүний хуулбар;
- хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа

Хурлын зар /"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 3.7/

- компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар;
- хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;
- хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;
- хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг;
- хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;
- компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл

Саналын хуудас /Компанийн тухай хуулийн 71.4/

- компанийн оноосон нэр;
- хурал хуралдах газар, өдөр, цаг;
- хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, түүний эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
- санал хураалтаар шийдвэрлэх асуудлын томъёолол, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
- төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийг сонгоход хэрэглэх санал хураах аргын нэр

Компанийн саналын эрх бүхий хувьцааны **50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид** хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно. /Компанийн тухай хуулийн 69.1/

- заасан хувьд хүрээгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг төлөөлөн удирдах зөвлөл товлох бөгөөд энэ тохиолдолд хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглоно. /Компанийн тухай хуулийн 69.3/

- хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ. /Компанийн тухай хуулийн 69.6/

1. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй. /Компанийн тухай хуулийн 63.10/
2. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон төлөөлөн удирдах зөвлөл, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүн /компанийн дүрэмд хурлаар хэлэлцэхээр заасан бол/-ий талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлагад гаргаж болно. /Компанийн тухай хууль 66.1/
3. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хориглоно./Компанийн тухай хуулийн 66.9/
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоно. /"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.8/
5. Хуралд оролцоогүй, эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь хурал зарлагч этгээдийг /"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 2.4, 3.1-3.4, 3.7-д заасныг зөрчсөн гэж үзэн Хороонд гомдол гаргасан бол түүнийг Хороо хянаж үзээд үндэслэлтэй гэж үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурал, эсхүл тухайн шийдвэрийг Компанийн тухай хуулийн 70.2-т заасан эрх хэмжээний дагуу хүчингүйд тооцно. /"Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 3.12/

2015 ОНЫ ХЭХ-ААР ГАРСАН НИЙТЛЭГ ЗӨРЧИЛ, ДУТАГДЛУУД

- Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, хурлын шийдвэр, баримт материалыг хууль, журамд заасан хугацаанд ирүүлээгүй
- Хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон асуудлаар гарсан тооллогын комиссын тогтоол, шийдвэр ирүүлээгүй
- Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ирцийн баталгаажилт, итгэмжлэл байхгүй
- Компанийн тухай хуулийн 60.4-д заасан хугацаанд хурлын зарыг олон нийтэд мэдээлээгүй
- Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг буруу тогтоосон г.м.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!

